



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 6 сарын 25 өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож,
үнэмлэх олгох тухай**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 74.3 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.9 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 17 дугаар тойрогт Монгол Ардын Намаас нэр дэвшиж 33783 сонгогчийн санал авсан Цэрэнпилийн Даваасүрэнг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсугай.

2. Цэрэнпилийн Даваасүрэнд Монгол Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлсүгэй.

ДАРГА *Ч. Содном* Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Ц. Болдсайхан* Ц.БОЛДСАЙХАН



00000777